

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	18



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.21. № 1-6/105
танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН 5 ДУГАА
БАГИЙН ЗАСАГ ДАРГА
Ц.ГАНЗОРИГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Ц.Ганзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-аас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

САЙНШАНД СУМЫН 5 ДУГААР БАГИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГ ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ 2020 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН 64 ДҮГЭЭР АЛБАН БИЧГЭЭР ИРҮҮЛСЭН БАЙНА.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны үйл ажиллагааны эрхэм зорилго нь төр эдийн засаг, нийгмийн бодлогын үйл ажиллагаа оршино.

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

2.5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын алба нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 616,168.2 мянган төгрөгөөс тооцон 12,323.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 12,323.4 мянган төгрөгөөр тооцсон нь хөрөнгийн хөдөлгөөн их гарсантай болбоотой.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 439,126.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	5861,5	0	-5861,5
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	2247,5	6986,9	4739,4
Үндсэн хөрөнгө	170330,4	610579,1	440248,7
Нийт хөрөнгө	178439,3	617566,1	439126,8
Өр төлбөр	448,4	2576,4	2128,0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	177990,9	614989,6	496998,8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	178439,3	617566,1	439126,8

Авлага дансны үлдэгдэл буурсан нь Татвар, Нийгмийн даатгал, Чандмань илч ОНӨХХК-уудтай холбоотой авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 3,600.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинэ конторын барилгатай шинэ автомашинтай болсон нь шалтгаалжээ. Үнэ төлбөргүй хүлээн авсан 466,589.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь Төрийн аудитын байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоогдсон актын төлбөрийг барагдуулаагүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 614,989.6 мянган төгрөг болж 496,998.8 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинэ байранд орсон шалтгаалжээ. Энэ нь ажилчдын ажиллах, хөдөлмөрлөх нөхцөл байдлыг сайжруулсан байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 145,827.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,500.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,600.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 148,598.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын 148,598.5 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэл 148,311.9 мянган төгрөг буюу 99.81 хувьтай байгаа нь төсвийн төлөвлөлтийг сайн хийсэнтэй холбоотой шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Сайншанд сумын ИТХ-с 4,800.0 мянган төгрөг, Сайншанд сумын ЗДТГ-с 14,058.8 мянган төгрөг, Аймгийн ИТХ-с 2,000.0 мянган төгрөг нийт 20,858.6 мянга төгрөг дээд шатны төсөв захирагчаас, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 250.0 мянган төгрөг нийт 21,108.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

Үүнээс Сайншанд сумын 5 дугаар багийн 11 дүгээр байрны дээврийн засварт-д 4,800.0 мянга, Нефтийн үйлдвэрийн 70 жилийн ойн арга хэмжээнд 12,500.0 мянга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх спортын арга хэмжээнд 2,000.0 мянга, Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албанд төрийн сангийн сүлжээг нүүлгэн шилжүүлэхэд 1,558.6 мянга, бусад үйл ажиллагаанд 250.0 мянга, нийт 21,108.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 12,042.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,858.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 2009.8 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 5,174.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 7,184.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2,009.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ.

Үүнд:

1. Илүү тооцож олгосон цалин нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь заалт “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5 дахь заалт нягтлан бодогч нь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Анхан шатны баримтгүйгээр олгосон томилолт нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалт “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Аудитаар илэрсэн 5,174.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Цалингийн хавтгайд бодогдож байгаа цалинг нийгмийн даатгал, татварын тайлантай, гарт олгож байгаа цалинг банкны жагсаалттай тулган үзэх мөн бүх ажил гүйлгээг харилцах дансны хуулгатай тулгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 122 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 13,861.4 мянган төгрөгийн зөрчилд 5,861.4 төлбөрийн акт тогтоосноос 3,285.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж 100 хувьтай байна.

2.14. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн шинжтэй 3,600.0 мянган төгрөгийн гадна тайзыг бараа материалын дансанд бүртгэсэн.

1.2. Эрсдэл: Үндсэн хөрөнгө алдагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС, дансны нэгдсэн зааврын дагуу хөрөнгийг бүртгэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу бүртгэнэ.

2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал.

2.1. Илрүүлэлт: Цалингийн хавтгайн тооцооллоос нийгмийн даатгалын тайлангаарх шимтгэлийн дүн 44.2 мянган төгрөгөөр зөрүүтэй.

2.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтлөх, төсөвт өглөг, авлага үүсгэх.

2.3. Өгсөн зөвлөмж: Татвар, нийгмийн даатгалын тооцооллыг цалингийн програмын бодолттой тулгах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тооцооллыг шалгаж ажиллана.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Шуудан холбооны зардлаас 1,530.0 мянган төгрөгийн материал худалдан авсан. Дээд шатны байгууллагаас дэмжлэг үзүүлсэн материалын зардлыг байгууллагын төсвөөс давхардуулан санхүүжүүлсэн.

3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

3.3. Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, дотоод хяналтыг сайжруулах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Давхардсан, ажил үйлчилгээг эргэж хянаад хариу албан бичгээр ирүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,108,946.37</u>	<u>6,986,980.19</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	2,247,480.00	6,986,980.19
354	Хангамжийн материал	2,247,480.00	6,986,980.19
35410	Бичиг хэргийн материал	131,800.00	176,300.19
35420	Аж ахуйн материал	2,115,680.00	6,810,680.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>170,330,372.71</u>	<u>610,579,110.23</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	170,330,372.71	610,579,110.23
392	Биет хөрөнгө	151,343,372.71	592,435,110.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	207,302,105.88	655,591,538.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-111,517,757.06	-129,344,387.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,790,000.00	28,090,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,452,000.08	-9,790,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,377,170.00	53,457,867.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,247,057.12	-24,237,311.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,257,790.00	22,707,790.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,672,148.44	-9,969,276.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,629,050.78	9,629,050.78
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,123,781.25	-3,700,161.17
393	Биет бус хөрөнгө	18,987,000.00	18,144,000.00
39301	Програм хангамж	1,264,500.00	1,264,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-421,500.00	-1,264,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,144,000.00	18,144,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>178,439,319.08</u>	<u>617,566,090.42</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>448,411.50</u>	<u>2,576,434.27</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	448,411.50	2,576,434.27
413	Өглөг	448,411.50	2,576,434.27
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	448,411.50	00.90
4136	Бусад өглөг	00.00	2,576,433.37
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,576,433.37
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>177,990,907.58</u>	<u>614,989,656.15</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	177,990,907.58	614,989,656.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	156,550,131.63	156,550,131.63
51101	Өмч: - төрийн	156,550,131.63	156,550,131.63
512	Хуримтлагдсан үр дүн	4,829,889.64	441,828,638.21
51210	Өмнөх үеийн үр дүн	4,829,889.64	4,829,889.64
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	436,998,748.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,610,886.31	16,610,886.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>178,439,319.08</u>	<u>617,566,090.42</u>

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	144,765,100.00	636,296,493.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	466,589,433.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	466,589,433.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	466,589,433.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	466,589,433.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,740,100.00	169,707,060.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,429,800.00	21,108,560.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,429,800.00	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,858,560.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	131,310,300.00	148,598,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	131,310,300.00	148,598,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	156,619,800.75	198,195,245.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,619,800.75	198,195,245.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,848,400.75	198,195,245.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,734,854.10	115,623,270.81
210101	Үндсэн цалин	88,433,907.00	91,305,944.90
210105	Гэрээт ажлын хөлс	8,300,947.10	24,317,325.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,756,305.34	14,134,524.93
210201	Тэтгэврийн даатгал	8,711,814.07	13,624,524.93
210202	Тэтгэмжийн даатгал	761,148.73	176,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	608,817.96	192,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	152,229.80	65,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,522,294.78	75,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,903,196.00	13,903,883.71
210301	Гэрэл, цахилгаан	1,004,455.00	879,580.81
210302	Түлш, халаалт	8,516,492.00	10,974,302.90
210303	Цэвэр, бохир ус	1,382,249.00	2,050,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,210,831.50	13,034,259.50
210401	Бичиг хэрэг	1,538,700.00	1,406,868.00
210402	Тээвэр, шатахуун	4,208,720.00	2,986,603.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,848,411.50	1,482,588.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,615,000.00	7,158,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.00	875,000.00
210604	Урсгал засвар	8,500,000.00	875,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	657,400.00
210702	Дотоод албан томилолт	00.00	657,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	519,068.00	10,648,013.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	299,068.00	10,348,013.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	40,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	220,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,901,545.81	29,318,893.48
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,901,545.81	29,318,893.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-11,854,700.75</u>	<u>438,101,247.57</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,971,882.73	1,102,499.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,102,499.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,971,882.73	-1,102,499.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-19,826,583.48</u>	<u>436,998,748.57</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>142,740,100.00</u>	<u>169,707,060.00</u>
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	142,740,100.00	169,707,060.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,429,800.00	21,108,560.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,429,800.00	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,858,560.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	131,310,300.00	148,598,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	131,310,300.00	148,598,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>142,740,100.00</u>	<u>165,626,363.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,740,100.00	165,626,363.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,968,700.00	165,339,818.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,560,636.31	108,547,355.81
210101	Үндсэн цалин	85,911,129.53	84,067,355.81
210105	Гэрээт ажлын хөлс	11,649,506.78	24,480,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,729,295.69	12,766,700.00
210201	Тэтгэврийн даатгал	8,325,395.69	6,903,500.00

Сайншанд сумын 5 дугаар багийн ажлын албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	1,101,000.00	1,581,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	819,863.20	1,521,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	281,036.80	826,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,202,000.00	1,933,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,093,900.00	13,590,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,004,455.00	846,902.00
210302	Түлш, халаалт	9,426,492.00	10,693,598.00
210303	Цэвэр, бохир ус	1,662,953.00	2,050,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,243,200.00	7,851,000.00
210401	Бичиг хэрэг	1,534,000.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,609,200.00	2,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	3,151,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.00	6,300,000.00
210604	Урсгал засвар	8,500,000.00	6,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	657,400.00
210702	Дотоод албан томилолт	00.00	657,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	519,068.00	15,626,863.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	299,068.00	15,326,863.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	40,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	220,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	40,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,771,400.00	286,544.19
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	286,544.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	286,544.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>4,080,697.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,080,697.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,080,697.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,080,697.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,080,697.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-4,080,697.00</u>

4.4 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	138,406,131.63	00.00	24,656,473.12	163,062,604.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	138,406,131.63	00.00	24,656,473.12	163,062,604.75
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	18,144,000.00	00.00	-19,826,583.48	-1,682,583.48
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,550,131.63	16,610,886.31	4,829,889.64	177,990,907.58
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,550,131.63	16,610,886.31	4,829,889.64	177,990,907.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,550,131.63	16,610,886.31	4,829,889.64	177,990,907.58
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	436,998,748.57	436,998,748.57
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,550,131.63	16,610,886.31	441,828,638.21	614,989,656.15

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	148,598,500.00	148,311,955.81	286,544.19	99.81
УРСГАЛ ЗАРДАЛ	148,598,500.00	148,311,955.81	286,544.19	99.81
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	148,598,500.00	148,311,955.81	286,544.19	99.81
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	108,833,900.00	108,547,355.81	286,544.19	99.74
Үндсэн цалин	84,353,900.00	84,067,355.81	286,544.19	99.66
Гэрээт ажлын хөлс	24,480,000.00	24,480,000.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,766,700.00	12,766,700.00	0.00	100.00
Тэтгэврийн даатгал	6,903,500.00	6,903,500.00	0.00	100.00
Тэтгэмжийн даатгал	1,581,200.00	1,581,200.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	1,521,800.00	1,521,800.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	826,600.00	826,600.00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	1,933,600.00	1,933,600.00	0.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,590,500.00	13,590,500.00	0.00	100.00
Гэрэл, цахилгаан	800,000.00	846,902.00	-46,902.00	105.86
Түлш, халаалт	10,740,500.00	10,693,598.00	46,902.00	99.56
Цэвэр, бохир ус	2,050,000.00	2,050,000.00	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	8,050,000.00	8,050,000.00	0.00	100.00
Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
Тээвэр, шатахуун	2,700,000.00	2,700,000.00	0.00	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,350,000.00	3,350,000.00	0.00	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	800,000.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	3,100,000.00	3,100,000.00	0.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.00
Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
Томилолт, зочны зардал	657,400.00	657,400.00	0.00	100.00
Дотоод албан томилолт	657,400.00	657,400.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.00

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.00
Даатгалын үйлчилгээ	40,000.00	40,000.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	220,000.00	220,000.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00	0.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	148,598,500.00	148,598,500.00	0.00	100.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	148,598,500.00	148,598,500.00	0.00	100.00
Орон нутгийн төсвөөс	148,598,500.00	148,598,500.00	0.00	100.00
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	0.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	18.00	0.00	0.00
Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	0.00
Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	0.00	0.00
Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00	0.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	21,108,560.00
УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	21,108,560.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	21,108,560.00
Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	4,800,000.00
Урсгал засвар	0.00	4,800,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	16,308,560.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	16,308,560.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	21108560.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	21,108,560.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	250,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	20,858,560.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		